

ҮЗЗ-ийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтын талаар									
ГС-ийн ҮЗЗ		Монгол Улс			Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн тоо			15	
Уулзалтын №		73							
Огноо		2017 оны 3 сарын 16			ҮЗЗ-ийн гишүүн бус оролцогчдын тоо, уригдаж ирсэн зочид			13	
ХУРЛЫН ДАРГА									
Нэр/ Байгууллага	Овог	Бямбасүрэн			Хурлын зорилгод хүрсэн эсэх (тийм, үгүй)			ТИЙМ	
	Нэр	Мягмар			Хурлын үргэлжилсэн хугацаа (цагаар)			4	
	Байгууллага	МҮЭ, Монголын Эрүүл Мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга			Хурал зохион байгуулагдсан газар	ЭМЯ, хурлын А танхим			
ҮЗЗ-д гүйцэтгэх үүрэг (Тохирох бөглөнө үү)	Дарга				Уулзалтын төрөл (Тохирох нүдийг бөглөнө үү)	Ээлжит	X		
	Дэд дарга					Ээлжит бус			
	Гишүүн				Бусад байгууллагын оролцоо (Тохирох нүдийг бөглөнө үү)	Хорооны уулзалт			
	Гишүүнийг орлогч					СОНА	X		
Салбар * (Тохирох нүдийг бөглөнө үү)									
ЗГ	ОУБ	ТББ	Боловсрол	Өвчлөлт бүлгийн хүн ам	Эрсдэлт бүлгийн хүн ам	Шашны Байгууллага	Хувийн Хэвшил	FPM / PO	
								бусад	X
								оролцоогүй	

ХӨТӨЛБӨР ТУС БҮРТ ХАМААРАХ СЭДВИЙГ СОНГОНО УУ (Тохирох нүдийг бөглөнө үү)															
ҮЗЗ-ийн ЗАСАГЛАЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ СЭДВҮҮД															
№	Хөтөлбөрийг дурдана уу	Ажлын явц	ҮЗЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийг хянах	АСЗ	ҮЗЗ-ийн гишүүнчлэлийн асуудал	Тогтвортой байдал	ҮЗЗ болон хамтрагч байгууллагуудын уялдаа холбоо	Хүйсийн эрх тэгш байдал	Төсөл боловсруулах	ҮХА, СХА	Тэтгэлэг	Хаяалт (удирдлага, СОНА аудит)	Санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох талаар / төслийн II үе/, хаалт	Техникийн тусалцаа авах шалгаруулалт	Бусад
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт	x													
Хөтөлбөр #2	ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн хөтөлбөрийн хуваарилалтыг хэлэлцэн батлах										x				
Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжих ХДХВ/ДОХ-ын Үргэлжлэх Шатны төслийн эхтэй танилцаж хэлэлцэн батлах	x							x				x		
Хөтөлбөр #4	Сүрьеэгийн шинэ төсөл боловсруулах ажлын явцын тухай мэдээлэл өгөх	x							x						
Хөтөлбөр #5	ҮЗЗ-ийн 2015-2017 оны санхүүгийн тайлантай танилцаж 2017-2020 оны санхүүгийн хүсэлтийг хэлэлцэн батлах												x		

Хөтөлбөр	
№	Хөтөлбөрийг дурдана уу
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт
Хөтөлбөр #2	ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн хөтөлбөрийн хуваарилалтыг хэлэлцэн батлах
Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжих ХДХВ/ДОХ-ын Үргэлжлэх Шатны төслийн эхтэй танилцаж хэлэлцэн батлах
Хөтөлбөр #4	Сүрьеэгийн шинэ төсөл боловсруулах ажлын явцын тухай мэдээлэл өгөх
Хөтөлбөр #5	ҮЗЗ-ийн 2015-2017 оны санхүүгийн тайлантай танилцаж 2017-2020 оны санхүүгийн хүсэлтийг хэлэлцэн батлах

Хөтөлбөр тус бүрээр хийсэн тэмдэглэл

Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт
--------------------	---

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх(тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Мягмар: ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар хурлыг даргалан хурлын хөтөлбөрийг гишүүдэд танилцуулж, гишүүд саналгүй тул хөтөлбөрийг батлав. 72 дах хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулав.

ХУРАЛ 2017-2-10

хөтөлбөр		ХАРНУЦАЖ БУЙ ХҮН	Гүйцэтгэл
хөтөлбөр#2	Өмнөговь аймгийн Цогцэций, Ханбогд сумдаас нэгийг нь сонгон тугалган хана болон рентген аппарат солих болно. Эмнэлгийн ажилчдын дунд халдвар авах магадлал өндөр байгаа учраас үүнд шаардагдах тусламж дэмжлэг, эмнэлгийн орчныг сайжруулах, халдвараас урьдчилан сэргийлэх ажилд анхаарал хандуулах шаардлагатай гэж шийдсэнийг гишүүд бүгд гараа өргөн баталлаа.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	ҮРГЭЛЖИЛЖ БАЙГАА
хөтөлбөр#4	<p>1. ҮЗЗ-ийн дарга Б. Мөнхцэцэгийн орлон гүйцэтгэгчээр Б.Мягмарыг гишүүдийн 80%-ийн саналаар томилох шийдвэр гарсан бөгөөд дараах шалтгаануудын улмаас энэхүү шийдвэрийг гарган баталсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийг өргөн барих цаг үе таарсан • Онцгой тохиолдол-жирэмсэний амралтаа авсан • Үүрэгт ажилдаа буцаж орох хугацаа тодорхойгүй зэргээс үүдсэн болно. <p>2. Хяналтын хорооны дарга ҮЗЗ-ийн дарга болсонтой холбогдуулан тус хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг хангах үүднээс Ц.Ганхүү, Ч.Энхтамир нарыг нэмж оруулсан. Түүнчлэн ҮЗЗ-ийн ажлын албанд Хяналтын хорооны ээлжит хурлыг яаралтай зарлан хуралдуулж даргыг нь сонгох ажлыг эрчимжүүлэхийг үүрэг болгон өглөө. (ҮЗЗ-ийн Хяналтын Хорооны гишүүдийн нэрсийг хавсаргав).</p>	ҮЗЗ-ийн гишүүд	100%

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТБ **Н.Амарсайхан:** Би ҮЗЗ-ийн дүрэмтэй танилцсан түүнчлэн энэхүү хуралд ирэхээсээ өмнө ҮЗЗ-ийн тухай мэдээллийг тодорхой хэмжээнд авсан бөгөөд ҮЗЗ-ийн дүрмийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу боловсруулах нь зүйтэй. Түүнчлэн ҮЗЗ нь хуулийн этгээд биш тул дүрэм батлах эрх бүхий байгууллага биш гэдгийг анхаарах хэрэгтэй.

ТБ **Л.Бямбасүрэн:** ҮЗЗ-ийн ажлын албанд эрхзүйч байх хэрэгтэй. Эсвэл хуулийн зөвлөгөө авах шаардлагатай гэдгийг дахин сануулмаар байна. Миний хувьд өнөөдрийн хурлаас чөлөө авч өөр хуралд оролцох хэрэгтэй байна.

Харцулт:

Б.Мягмар: Та бүхний хэлсэн саналуудыг ойлголоо. Н.Амарсайхан танд дүрэмтэй холбоотой аливаа асуудал байвал бидэнд бичгээр саналуудаа мэдэгдэж хурал дээр хэлэлцэх нь зүйтэй.

Хөтөлбөр #2	ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн хөтөлбөрийн хуваарилалтыг хэлэлцэн батлах
--------------------	--

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Мягмар: Глобаль сангаас Монгол улсыг 2018-2020 онд хэрэгжүүлэх ХДХВ/ДОХ, Сүрьеэ болон эрүүл мэндийн уян хатан, тогтвортой системийг бий болгоход 10,269,067 ам.долларын төслийг боловсруулан хүргүүлэх боломжийг олгосон. Үүнээс 3,044,708 ам.долларын санхүүжилт нь ХДХВ/ДОХ-ын үргэлжлэх шатны төсөлд, 7,224,359 ам.долларын санхүүжилт нь Сүрьеэгийн төсөлд тус тус хуваарилагдах юм, ХДХВ/ДОХ-ын төслийн санал хүлээн авах сүүлийн хугацаа нь 2017 оны 3-р сарын 20-ны өдөр, Сүрьеэгийн төслийг 2017 оны 5-р сарын 23-ны өдөр өргөн барих болно. Монгол улсын хувьд Дэлхийн банкны судалгаагаар дундаас дээгүүр орлоготой улс гэж ангилагдсан. Аливаа улсын үндсэн зарчим дээр тулгуурлан ҮЗЗ нь эрх бүхий өвчний бүрэлдэхүүн хэсгийн хөрөнгийн хуваарилалтыг хийх эрхтэй байдаг. Тиймээс хүсэлт гаргагч нь Глобаль сангийн хөтөлбөрийн хуваарилалтыг хүлээн авах эсвэл шинэчилсэн хуваарилалтыг Глобаль санд санал болгож, хянуулж болно. Та бүхэн Глобаль Сангаас хувиарласан дараах хөтөлбөрийн хуваарилалтыг дэмжиж байгаа эсэхээ гараа өргөн бидэнд саналаа өгнө үү.

Хөтөлбөрийн хуваарилалт хуваалтын тойм

Эрх бүхий өвчний бүрэлдэхүүн хэсэг	Хуваарилалт ам.доллар	Хуваарилалтын ашиглалтын хугацаа
ХДХВ	3,044,708	2018/01/01-2020/12/31
Сүрьеэ	7,224,359	2018/01/01-2020/12/31
Бүгд	10,269,067	

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Шийдвэр: Глобаль сангийн санал болгож буй хөтөлбөрийн хуваарилалтыг гишүүд бүгд гараа өргөн дэмжлээ.

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		15
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түтгэлзэх		

Хөтөлбөр #3 2018-2020 онд хэрэгжих ХДХВ/ДОХ-ын Үргэлжлэх Шатны төслийн эхтэй танилцаж хэлэлцэн батлах

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

байхгүй

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тний эсвэл үгүй)>

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Тийм

А.Нямдорж: ДОХ-ын төслийн өмнөх 3 жилийн үйл ажиллагааны төсөв нь 5 сая ам.доллар байсан бөгөөд 2017-2020 онд хэрэгжих үргэлжлэх шатны төсөлд 3 сая ам.доллар хуваарилсан ба эрүүл мэндийн бат бөх, тогтвортой систем, түлхүүр хүн ам, ЭМ-ийн стратеги нэмэгдсэн боловч санхүүжилт 40%-иар багассан. ДОХ-ын Ажлын хэсгийн ахлагчаар А.Нямдорж миний бие ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 10 гаруй удаа хуралдсан ба олон талт зөвлөлдөх уулзалтыг амжилттай зохион байгуулсан. Тэдгээрээс гарсан санал зөвлөмжүүдийг төсөлдөө тусган ажиллах саналуудыг авсан. Үндэсний зөвлөхөөр Т.Отгонбаатар, олон улсын зөвлөхөөр Тед Ниеррас, Скот Берри нарыг ажиллуулахаар Гүйцэтгэх хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэний дагуу ажиллаж Глобаль санд илгээх хүсэлтийг ҮЗЗ-ийн ажлын албатай хамтран боловсруулсан.

Тед Ниеррас:

1. Глобаль Сангийн ХДХВ/ДОХ-ын Үргэлжлэх Шатны төсөл боловсруулах ажлын 6 хэсгийн дэлгэрэнгүй тайлбар, танилцуулга /Хавсралт 1/
2. Modular framework-ын танилцуулга /Хавсралт 2/
3. СХА-дын илгээсэн төсвийн нарийвчилсан задаргаа /Хавсралт 3/ зэргийг танилцууллаа.

Эдгээр танилцуулга материалууд дээр ажлын хэсгийн оролцогчид өөрсдийн саналыг тусган сайжруулах боломжтой гэдгийг сануулсан бөгөөд хавсралтаар ажлын хэсгийн хурлуудын тэмдэглэлийг оруулахаа мэдэгдлээ.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Д.Ганццэг: Хүний нөөц, анхан шатны тусламж үйлчилгээ, төрийн бодлогын үр дүнтэй байдлыг сайжруулах хэрэгтэй байна. Түүнчлэн энэхүү төслийн талаар сурталчилгааны үйл ажиллагаа байхгүй байна. ҮХА-ын хувьд ЭМЯ санхүүжилтын 35%-ыг авч ажиллах хэрэгтэй байна.

ТБ

Хувийн хэвшил	Б.Мягмар: Ажлын хэсэг, олон улсын зөвлөхүүд энэ урт хугацаанд ажиллаж байхад өдийг хүртэл ҮХА саналаа өгөөгүй байгаа нь сонин байна. ҮЗЗ-ийн гишүүд ҮЗЗ-ийн ажлын албанд өөрсдийн саналыг бичгээр ирүүлбэл ХЗН-д илгээн нэмэлт өөрчлөлтийг хийх боломжтой гэдгийг хэллээ.		
Хариулт:			
Шийдвэр:	Глобаль санруу илгээх ХДХВ/ДОХ-ын төслийн санхүүжилтийн хүсэлтийн баримт бичгийг гишүүд бүгд гараа өргөн дэмжиж байгаагаа илэрхийллээ.		
Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	x		
Санал хураалт	x	Санал хураалт (Төхирөх нүднийг бөглөнө үү)	Гар өргөх x
			Нууц санал хураалт
		Дэмжсэн>	15
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #4	Сүрьеэгийн шинэ төсөл боловсруулах ажлын явцын тухай мэдээлэл өгөх		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>			
			Тийм
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй			
Б.Мягмар: 2018-2020 онд хэрэгжүүлэх Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн шинэ төсөл боловсруулах ажлын хэсгийн /Хавсралт 4/ үйл явцын талаархи танилцуулгыг хийлээ. Ажлын хэсгийн ахлагчаар миний бие ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 2 удаа хуралдсан ба олон талт зөвлөлдөх уулзалтыг амжилттай зохион байгуулсан.			
Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга			
Хөтөлбөр #5	ҮЗЗ-ийн 2015-2017 оны санхүүгийн тайлантай танилцаж 2017-2020 оны санхүүжилтийн хүсэлтийг хэлэлцэн батлах		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Байхгүй.			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>			
			үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй			
Б.Оюундарь:			
<ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн 2015-2107 оны санхүүгийн тайлан /Хавсралт 5/. 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн санхүүгийн тайланг гүйцэтгэлийн хамт танилцуулав. Санхүүгийн жил дуусч үйл ажиллагаа 3 сарын 31-ний өдрөөр тасалбар болмогц гишүүдэд бүтэн жилийн санхүүгийн тайланг илгээх боломжтой. • 2017-2020 оны санхүүжилтийн хүсэлт /Хавсралт 6/. Улс орнуудын ҮЗЗ-ийн хэрэгцээ шаардлагыг харгалзаж өнгөрөгч жилүүдийн санхүүгийн хүсэлтийн хэмжээг үндэслэн Монгол улсын ҮЗЗ-ийн ажлын албаны зардлыг 2017-2020 онуудад 60.000 ам.доллараас хэтрүүлэхгүй ажлын төлөвлөгөөг илгээх шаардлагыг тавьсаны дагуу бид өмнөх жилүүдийн үйл ажиллагааг дотоодын баримталдаг тариффын дагуу бөглөн илгээх гэж байна. 			
Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга			
ТБ	Д.Ганцэцэг: ҮЗЗ-ийн хуралд цаг заваа зарцуулан ирж оролцож байгаа хүмүүст цагийн мөнгө тооцож		

	олгох хэрэгтэй. Түүнчлэн эдгээр хурлуудыг хотоос гаргаад ая тухтай газар хийх боломжтой санагдаж байна.
ТБ	Н.Амарсайхан: Хуулиар бол монгол улсын төр засагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид ийм ОУ-ын төсөл хөтөлбөрөөс ямар нэг урамшуулал авах ёсгүй.
Залуусын байгууллага	А.Нямдорж: Хуулийн зөвлөгөөг цаг тухайд нь аваад явах нь зөв. Гэхдээ орон тоогоо өөрчлөх тал дээр санал нийлэхгүй байна.
МСНЭ	Ч.Энхтамир: Бид энд зугаацах гэж ирээгүй тул байр сууриа зөв илэрхийлж аливаа урамшуулал авхаас татгалзах хэрэгтэй. Үгүй бол хүн бүр төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй болох сул талтай.

Хариулт:

Б.Оюундарь: Д.Ганцэцэг даргын хэлсэн саналыг урьд өмнө олон гишүүд гаргаж байсанчлан би Глобаль Сантай холбогдож асуусны дагуу тэд бидэнд Глобаль сангийн удирдамжийг илгээсэн. Энэхүү удирдамж дээр ҮЗЗ-ийн гишүүд ямар ч урамшуулал авах боломжгүй гэдгийг тодорхой заасан байна. Манаб Баснет ч үүнийг өөрийн айлчлалын үеэр дурдсан. Харин энэ оны 4 дүгээр сард Глобаль Сангаас гишүүдэд зориулсан чиг баримжаа олгох томоохон хөтөлбөр орж ирж байгаа ба гадны мэргэжилтэнгийн хамт бид зохион байгуулах болно. Та бүхэн тус үйл ажиллагаанд идэвхитэй оролцно гэж найдаж байна.

Шийдвэр:

Глобаль санруу илгээх ҮЗЗ-ийн 2017-2020 оны санхүүжилтийн хүсэлтийн баримт бичгийг гишүүд бүгд гараа өргөн дэмжиж хүсэлт баталгаажуулах хуудас дээр гарын үсгээ зурлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		15
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#2	Глобаль сангийн санал болгож буй хөтөлбөрийн хуваарилалтыг гишүүд бүгд гараа өргөн дэмжлээ.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	
хөтөлбөр#3	Глобаль санруу илгээх ХДХВ/ДОХ-ын төслийн санхүүжилтийн хүсэлтийн баримт бичгийг гишүүд бүгд гараа өргөн дэмжиж байгаагаа илэрхийллээ.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	
хөтөлбөр#5	Глобаль санруу илгээх ҮЗЗ-ийн 2017-2020 оны санхүүжилтийн хүсэлтийн баримт бичгийг гишүүд бүгд гараа өргөн дэмжиж хүсэлт баталгаажуулах хуудас дээр гарын үсгээ зурлаа.	ҮЗЗ-Н ГИШҮҮД	

ДАРААГИЙН ХУРАЛ(ОГНОО, ХӨТӨЛБӨР)

Огноо	2017 он
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр


Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	Х	
Хөтөлбөр	Х	
Бусад /илтгэлүүд/	Х	
Хавсралт 1-10	Х	

БЭЛТГЭЛ АЖИЛ (Төхирөх нүдийг бөглөнө үү)			
	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон оролж ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах


ТОВЧИЛСОН ҮГ:

Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
АСЗХ	Ашиг сонирхлын зөрчлийн хороо
ЭМ	Эрүүл Мэнд

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2017 оны 3 сарын 20
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	

ХЯНАСАН:

Нэр>	Б.Оюундарь	Огноо>	2017 оны 3 сарын 20
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	

БАТАЛСАН:

Нэр>	Б.Мягмар	DATE >	2017 оны 3 сарын 20
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	